



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/360

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Малын шүлхий өвчний үед эрүүл мэндийн байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээний зааврыг хавсралтаар баталсугай.
2. Зааврыг хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв /Н.Цогбадрах/, нийслэл, аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төв, өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2001 оны 44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 10 өдрийн
1360 дугаар тушаалын хавсралт

МАЛЫН ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

1. Тодорхойлолт

- 1.1. Шүлхий өвчин нь тэмээ, үхэр, сарлаг, хонь, ямаа, гахай, буга, зээр зэрэг салаа туурайтан амьтан өвчилдөг, вирусийн гаралтай малын гоц халдварт өвчин юм.

2. Үүсгэгч

- 2.1. Шүлхий өвчний үүсгэгч нь РНХ агуулсан 10-20 нм хэмжээтэй Пикорновиридэ ангийн Афтовирус зүйлд хамаардаг хамгийн бага хэмжээтэй вирус юм.
- 2.2. Шүлхийн вирус нь дархлаа төрүүлэх чанараараа 7 хэвшил (А, О, С, Ази-1, CAT-1, CAT-2, CAT-3), 60 гаруй дэд хэвшилтэй, гадаад орчинд тэсвэртэй, рН 6.0-аас доош, 9.0-өөс дээш буюу хүчтэй хүчиллэг болон шүлтлэг орчинд тэсвэргүй, 2 хувийн идэмхий натри, 2 хувийн сод, 0.2 хувийн нимбэгийн хүчил, 2 хувийн цууны хүчил, Hi-Cor гэх мэт бодисуудад мэдрэг. Хлорын шохой, фенол, аммонийн нэгдэлд харьцангуй тэсвэртэй.

3. Тархалт

- 3.1. Мал, амьтны шүлхий өвчин Ази, Африк, Европын улс орнуудад өргөн тархсан. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын мэдээллээр шүлхийн вирусийн А, О, Ази-1, CAT-1, CAT-2, CAT-3 дэд хэвшлээр үүсгэгдсэн мал, амьтны өвчлөл Ази, Африк, Өмнөд Америк, Евро-Азийн 90 гаруй улс орнуудад тархсан байна.
- 3.2. 2000-2017 онд 12 аймгийн 50 гаруй сум, Нийслэлийн зарим дүүрэгт шүлхийн О, А, Ази-1 хэвшлийн вирусээр үүсгэгдсэн малын өвчлөлийн дэгдэлт бүртгэгдсэн.

4. Тархвар судлал

- 4.1. Эх уурхай: Шүлхийгээр өвчилсөн мал, амьтад халдварын эх уурхай болно.
Өвчтэй мал, амьтнаас ялгарч байгаа бүхий л шүүрлүүд, шүлс, өтгөн, шингэнээр вирус ялгарч, малын хашаа саравч, хөрс шороо, өтөг бууц, ус, бэлчээр, эд зүйлсийг бохирдуулан богино хугацаанд олон мал, амьтныг өвчлүүлэн дэгдэлт хэлбэрээр тархдаг.
- 4.2. Халдвар дамжих зам: Өвчтэй мал, амьтны бүхий л шүүрлүүд, шүлс, сүү, өтгөн, шингэнээр ялгарсан вирусээр бохирлогдсон гадаад орчин, малын хашаа саравч, хөрс шороо, өтөг бууц, ус, бэлчээр нь халдвар дамжих үндсэн зам болдог. Хүн шүлхий өвчнөөр өвчлөх эрсдэл маш бага хэдий ч

шууд хавьтлын зам, хоол боловсруулах замаар халдвар дамжиж болно. Хүнээс хүнд халдвар дамжихгүй.

- 4.3. Нууц үеийн хугацаа: Өвчний нууц үе 3-6 хоног байна.
- 4.4. Өртөмхий бүлэг: Малчид, бага насны хүүхдүүд, өндөр настан, мах, сүү, арьс ширний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид, малын эмч, мал эмнэлгийн мэргэжилтнүүд, голомтод дайчлагдан ажиллаж байгаа хүмүүс эрсдэлт бүлэгт хамаарна.
5. **Эмнэлзүйн шинж тэмдэг**
- 5.1. Өвчин эхлэхдээ 38-39 хэм хүрч халуурч, ерөнхий хордлогын шинж тэмдэг илэрнэ. Амны хөндийн салст улайж, уруул хөөнгөтөж хавдана. Шүлс их хэмжээгээр гоожино. Амны хөндий, хамрын салст, хамар амны эргэн тойронд болон гар хөлийн хумс, сарвуунуудын хооронд цэврүүт өнгөц шархлаат тууралт гарна.
- 5.2. Эмнэлзүйн ангиллын хувьд арьсны, салстын, арьс-салстын хэлбэрээр тохиолдож болно.
6. **Ялган оношилгоо**
- 6.1. Шүлхийгээр хүн өвчилсөн тохиолдлыг амны хөндийн шархлаат үрэвсэл (*херпес вирусийн стоматит*), салхинцэцэг, гар хөл амны өвчнөөс ялган оношилно.
- 6.2. Амны хөндийн шархлаат үрэвслийн үед шарх нь гүн, ирмэг нь тэгш, шархны ёроол нь цагаавтар өнгөртэй байна.
- 6.3. Салхинцэцэг өвчний үед биеийн байдал нь харьцангуй хөнгөн байх ба тууралт бүх биеэр гарна.
- 6.4. Гар хөл амны өвчний үед хоолой, залгиур улайж, амны хөндийн салст, завьж, буйл, хэл, тагнай, гарын алга, хөлийн ул зэрэгт толбот гүвдрүүт цэврүүт тууралт гарна.

7. **Лабораторийн оношилгоо**

- 7.1. Лабораторийн шинжилгээнд өвчтөнөөс дараах сорьцыг авна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Сорьцын нэр, төрөл, хугацаа, хэмжээ

Сорьцын нэр	Сорьц авах хугацаа	Хэмжээ
Өвчтөн		
Цусны ийлдэс	Шинж тэмдэг эхэлснээс хойш 1-5 хоногт	0,5-1,0 мл
Цус		5 мл
Шүлс		0,5-1,0 мл
Цэврүүт тууралтын арчдас		0,5-1,0 мл
Ялгадас		50 мл
Гадаад орчин		
Өвчтэй малын сорьц (мах, сүү)	Эх уурхайг тодорхойлох	0.3 л

7.2. Сорьц хадгалах, тээвэрлэх

- Сорьцыг 24 цагийн дотор лабораторид хүргэх бол -20 хэмд, 24 цагаас дээш хүргэхээр бол -70 хэмд хадгална.
- Сорьц тээвэрлэхдээ олон улсын агаарын тээврийн ассоциац (IATA-international Air Transport Association)-аас зөвлөмж болгосон гурван савалгааны горимыг баримтлан хаяглаж, битүүмжлэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журмын дагуу тээвэрлэнэ.

7.3. Лабораторийн шатлал, хамрагдах байгууллага, төрлүүд

Шатлал	Хамаарах байгууллага	Шинжилгээний төрөл
Анхан шат	- Өрх, сумын эрүүл мэндийн төв - Дүүргийн нэгдсэн эмнэлэг - Зоонозын өвчин судлалын төвгүй аймгуудын нэгдсэн эмнэлэг - Хувийн хэвшлийн эмнэлэг	Лабораторийн шинжилгээнд сорьц авна.
Хоёрдогч шат	- Аймаг нийслэлийн ЗӨСТ	- Сорьц авах - Ийлдэс судлалын шинжилгээ
Үндэсний түвшин	- ЗӨСҮТ-ийн лавлагаа лаборатори	- Сорьц авах - Хурдавчилсан сорил - Дархан туяарах урвал - ФХЭБУ - ПГУ

8. Эмчилгээ

№	Эмийн нэр	Тун	Хэрэглэх арга	Нийт тун
Шалтгааны эсрэг				
1	Гроприносин	500 мг	Уух	1х3-аар 5 хоног
2	Циклоферон (12.5%-2 мл)	2 мл/хоног	Булчинд, эхний 3 хоног дараалан цаашид өнжиж тарих	10 удаа
Хоёрдогч халдвараас сэргийлэх				
1	Доксициллин	Насанд хүрэгсэд-100 мг 9-с дээш насны хүүхдэд 50 мг	Өдөрт 2 удаа уух	5 хоног
2	Метронидазол	Насанд хүрэгсэд-250 мг шахмал Хүүхэд-125 мг шахмал	Өдөрт 3-4 удаа уух	5-7 хоног
3	Ампициллин	Насанд хүрэгсэд-500 мг/кг Хүүхэд-250 мг	6 цагаар, булчинд	10-14 хоног

Хэсэг газрын эмчилгээ

- Амны хөндийг 0,7%-ийн тамедин, фурациллины 1:5000 уусмалын аль нэгээр өдөрт 2-3 удаа зайлуулна.
- Амны хөндийн тууралт их хэмжээтэй тохиолдолд өвдөлт намдаах эм уулгасны дараа хооллоно.

9. Хяналт, сэргийлэлтийн арга хэмжээ

- 9.1. Шүлхийн мал, амьтны өвчний дэгдэлт бүртгэгдсэн тохиолдолд Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаалаар батлагдсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-ын дагуу мал эмнэлгийн байгууллага тэргүүлэн, салбар хоорондын байгууллагууд хамтран хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 9.2. Шүлхийн хүний өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ЗӨСҮТ, салбар хоорондын байгууллагуудтай хамтран эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлийн түвшин дундаас доош тохиолдолд мэргэжлийн байгууллага холбогдох журам, зааврын хүрээнд хариу арга хэмжээг зохион байгуулна.
- 9.3. Нийслэл, аймгийн Эрүүл Мэндийн Газраас шүлхий өвчний үед дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
 - 9.3.1. Шүлхий өвчний хөл хорионы бүсэд ажиллаж байгаа ажилтан албан хаагч, амьдарч буй иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээг зохион байгуулна.
 - 9.3.2. Шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрт ажиллаж буй хариу арга хэмжээний хамтарсан багийн зөвлөмжийн дагуу, холбогдох мэргэжлийн эмч, багийг дуудан тусламж авах, дараагийн шатлалын эмнэлэгт хүргэх үйлчилгээг зохион байгуулна.
 - 9.3.3. Малын шүлхий өвчний голомтын болон сэжигтэй бүсэд байгаа иргэдийн судалгааг гарган, эрсдэлт бүлгийн (0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд) судалгааг нарийвчлан гаргаж хяналтад авна.
 - 9.3.4. Эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангуулж, орон байр, эм, багаж, тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис бусад эд зүйлс, бараа материалын нөөц бүрдүүлж ажиллана.
 - 9.3.5. Голомтын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар аймаг, сум, дүүргийн засаг захиргаа, онцгой байдал, мэргэжлийн хяналт, мал эмнэлгийн болон бусад салбар хоорондын байгууллагуудтай мэдээ, мэдээлэл тогтмол солилцоно.
 - 9.3.6. Малын өвчний голомтод аймаг, сум, дүүргийн засаг захиргаа, мэргэжлийн бусад байгууллагатай хамтран халдваргүйтгэлийн нэвтрэх цэгийг байгуулан голомтод ажиллаж байгаа ажилтан албан хаагч, иргэд, зорчигчдын эрүүл мэндийг хамгаалах, халдварын эрсдэлээс

урьдчилан сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулж, дараах ажлуудыг холбогдох байгууллагаар хийж гүйцэтгүүлнэ. Үүнд:

- 9.3.6.1. Голомтын бүсэд байгаа болон зорчигчдод эрүүл мэндийн үзлэг хийж, арьс салстад цэврүүт шарх гарсан, халуурсан эсэхэд хяналт тавьж, бүртгэл хөтлөх, хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрсэн үед эмнэлэгт тусгаарлан хэвтүүлж, лабораторийн шинжилгээнд сорьц авч, оношийг яаралтай тодруулан эмчилж, холбогдох хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
 - 9.3.6.2. Хяналтын цэгээр нэвтэрч буй зорчигчдын биеийн ил хэсгийг 0.2%-ийн нимбэгний хүчил, санитол, содын 2%-ийн уусмал, 70%-ийн спирт агуулсан бодисоор арчуулж нэвтрүүлэх;
 - 9.3.6.3. Амны хөндий, хоолой залгиурыг 0.2%-ийн нимбэгний хүчил, 0.7%-ийн тамедин, 1:5000-ийн фурациллин, 2%-ийн давсны болон содын бүлээн уусмалуудын аль нэгээр зайлуулах;
 - 9.3.6.4. Гутлын гадаргууг 0.1%-ийн жавелион эсвэл Hi-Cor-ийн уусмалаар шүршиж, улыг 2-3 метрийн урттай халдваргүйтгэлийн бодис шингээсэн замаар гишгүүлж халдваргүйтгэх;
 - 9.3.6.5. Гадуур хувцсыг уур-агаарын аргаар (70-85 хэм) 45 минут халдваргүйтгэх;
 - 9.3.6.6. Хүн амд халдвараас урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийх үйл ажиллагааг зохион байгуулах;
- 9.3.7. Шүлхий өвчинтэй холбоотой үйл явдлын тандалт хийж, үйл явдал бүртгэгдсэн тухай бүрт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг дээд шатны болон мэргэжлийн төв байгууллагад хөл хорио цуцлагдсанаас хойш нэг сарын дотор хүргүүлнэ.

9.4. Аймгийн ЗӨСТ-өөс шүлхий өвчний үед дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- 9.4.1. Аймаг, сум, дүүргийн засаг захиргаа болон мэргэжлийн бусад байгууллагатай хамтран ажиллана.
- 9.4.2. Голомтын байнгын болон эцсийн халдваргүйтгэл, мал, малын сэг зэм устгалын үйл ажиллагаанд хяналт тавьж, бүртгэлжүүлнэ.
- 9.4.3. Голомтод ажиллагсдын хувийн хамгаалах хувцас хэрэгсэл тогтмол өмсөх, гар угаах зэрэг хөдөлмөр хамгаалал, биоаюулгүй ажиллагаанд хяналт тавина.
- 9.4.4. Биеийн ил хэсэгт шархтай үед өвчтэй мал, амьтан, халдварын сэжигтэй зүйлтэй харьцуулахгүй байх асуудлыг эрх бүхий албан тушаалтнаар шийдвэрлүүлнэ.
- 9.4.5. Хүн амд шүлхий өвчний халдвараас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгааг хийнэ.
- 9.4.6. Хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар аймаг, сум, дүүргийн захиргаа, онцгой байдал, мэргэжлийн хяналт, мал эмнэлгийн болон бусад салбар

хоорондын байгууллагуудтай мэдээ мэдээлэл тогтмол солилцож, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллана.

9.4.7. Малын өвчлөлтэй холбоотой үйл явдлын мэдээ, мэдээлэл авч нэгтгэх, хамтарсан дүгнэлт гаргахад оролцоно.

9.4.8. Хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед холбогдох эрхзүйн хүрээнд хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллана.

10. Голомтын халдваргүйтгэл

Монгол улсад зөвшөөрөгдсөн халдваргүйтгэлийн бодисыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу найруулж, үйлчлэх хугацааг нарийн тооцоолж, дараах хүснэгтэд заасны дагуу ажиллана (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Халдваргүйтгэл хийх аргачлал

№	Эд зүйлсийн нэр	Арга	Бодисын нэр	Хугацаа
1	Амны хөндий, хоолой, залгиур	Зайлах	- 0.2%-ийн нимбэгийн хүчил - 0.7%-ийн тамедин - 1:5000-ийн фурациллин - 2%-ийн давсны уусмал - 2%-ийн содын уусмал	5 минут
2	Гар халдваргүйтгэх	Арчих Угаах	- 70%-ийн спирт агуулсан гар халдваргүйтгэх бодис - Саван - Санитол	45 сек
3	Биеийн ил гарсан хэсэг	Арчих	- 0.2%-ийн нимбэгийн хүчил - 2%-ийн содын уусмал - 70° этилийн спирт	45 сек
4	Гутлын гадаргуу, ул	Гишгэх, арчих	- Hi-Cop 1:2000. 1м²-д 200 мл-300 мл - 1%-ийн Виркон - 3%-ийн устөрөгчийн хэт исэл - 0.5%-ийн оксифлор - 0.1%-ийн жавелион	2-3 метр халдваргүйт-гэлийн бодис шингээсэн зам
5	Зорчигчдын гадуур хувцас	Уураар	Уур-агаарын холимгоор (70-85 хэм)	45 минут
6	Тээврийн хэрэгсэл	Уураар утах	- 4%-ийн содын уусмал	40 минут
		Шүрших	- 1%-ийн Виркон С - 3%-ийн устөрөгчийн хэт исэл - 0.5%-ийн оксифлоор - Hi-Cop 1:2000. 1м²-д 200 мл-300 мл	30 минут
7	Халдварын эх уурхай, сэжигтэй сорьц материал	Шатаах Автоклавдах	- 1.0 атм 120°	1 цаг

8	Орон байр, гэр майхан тавилгын гадаргуу	Шүрших арчих норгох	- 3%-ийн устөрөгчийн хэт исэл - Hi-Cop 1:2000 - 0.2%-ийн нимбэгийн хүчил - 2%-ийн цууны хүчил - 1%-ийн Виркон С	1 цаг 2 цаг 2 цаг 2 цаг
9	Хамгаалах өмсгөл	Автоклавдах, уусмалд дүрэх	1.0 атм 120° - 0.5%-ийн угаагч нунтагтай 3%-ийн устөрөгчийн хэт исэл	30 минут 1 цаг
10	Бээлий	Уусмалд дүрэх эсвэл шатаах	3%-ийн устөрөгчийн хэт исэл	1 цаг
11	Нүдний шил, чагнуур	Дүрэх арчих	70° этилийн спирт	1 цаг
12	Усны гутал	Дүрж арчих	- Hi-Cop 1:2000 - 3%-ийн гипохлорит натри - 0.2%-ийн нимбэгийн хүчил - 2%-ийн цууны хүчил - 0.5%-ийн угаагч нунтагтай 3%-ийн устөрөгчийн хэт исэл - 0.1%-ийн жавелион	
13	Нэг удаагийн өмсгөл	Шатаах		